

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРЭГДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2016 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

Тус хэлтэс нь 2016 онд улсын албан ёсны мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, графикт хугацаанд нь шуурхай нийлүүлэх, эдийн засгийн үзүүлэлтээр олон жилийн динамик судалгааны сан бүрдүүлэх, дүүргийн статистикийн эмхэтгэл, сар бүр нийгэм, эдийн засаг болон захиргааны статистикийн чиглэлээр танилцуулга гаргах, ажилчдын ажлын цаг ашиглалт, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллах зорилт дэвшүүлэн амжилттай хэрэгжүүлж байна.

**1. СТАТИСТИКИЙН МЭДЭЭ ТАЙЛАН:**

Жилийн эхнээс мэргэжилтэн нэг бүрээр ажил үүргийн хуваарь, ажил орлон гүйцэтгэх хуваарь, танилцуулга хариуцан гаргах хуваарийг гаргалаа. ҮСХ болон НСГ-т дамжуулах албан ёсны болон захиргааны статистик мэдээ, тайланг **5129** ААНБ-аас заавар аргачлалын дагуу гаргуулан авч, шалган, нэгтгэж, алдаагүйгээр графикт хугацаанд нь шуурхай дамжуулж ажиллаа. Албан ёсны статистикийн 48 мэдээ, улсын хэмжээний 5 судалгааг авч байна.

Албан ёсны статистикийн мэдээ /жилийн эцэст өссөн дүнгээр/

АҮ-1	230
тээвэр	73
ШХИҮ	151
СС-1	4
НБХҮ	207
СХ-1	75
ИБ-1	78
НБХҮ-1	207
ТББ-1	349
МТС-1	133
сөх	43
ХУ-1	584
ХУ-1а	183
АЖ-1	121
ҮҮМ-1	10
ЗБ-1	81
ОСНАА-1	20
ОС-1	22
ХА-3	19
ХА-2-1	40

МШУ	110
СБТ-1 жилийн	23
МЭ-1	3
ЭШС-1.1	174
ЭШС-1	112
АҮ-7	408
СБТ-1	36
БР-3	19
БЗҮ-1	52
Үнэ-1	7
БЗҮ-1а	61
ХО	225
БР	676
ЗГ-1а	54
ЗГ-1	31
ИБ-4	510
ҮХХ	241
ОАА	9
ХАА	36

Түүвэр судалгаанд сонгогдсон нэгжээс судалгааг цаг хугацаанд нь маягтаар авч программын дагуу боловсруулж дамжуулсан.

Үүнд:

- “Хөрөнгө, хөрөнгө оруулалтын судалгаа”-г улирал бүр
- “Ажиллах хүчний судалгаа” сар бүр
- “Өрх, нийгэм, эдийн засгийн судалгаа” сар бүр
- “ААНБ-ын тооллого” 5 жилд нэг удаа
- “Байгаль орчны зардлын судалгаа”
- Нөөц ашиглалтын хүснэгт, салбар хоорондын зардлын судалгаа
- Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа
- Мэдээлэл, харилцаа холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индексийн тооцоонд ашиглах суурь үнэ цуглуулах судалгаа

### **ХОЁР: СТАТИСТИКИЙН ТООЛЛОГО, СУДАЛГАА:**

1. Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, “з” дэх заалтын дагуу “Аж ахуйн нэгжийн тоологыг 5 жил тутам” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн “Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын тов тогтоох тухай” 163 дугаар тогтоол, Монгол улсын хууль зүйн сайдын 2016 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/90 дугаар “Аж ахуйн нэгж байгууллагын улсын тооллого явуулах тухай” тушаал, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 4 сарын 1-ний өдрийн 262 тоот захирамж, Дүүргийн Засаг даргын 2016 оны 4 сарын 12-ны А/287 тоот захирамийн дагуу Дүүргийн нутаг дэвсгэрт ААНБ-ын улсын тооллогыг онлайн буюу уламжлалт аргаар тоолж, байршлыг тогтоож, орон зайн мэдээлэл бүхий цахим сан үүсгэх ажил анх удаа хийгдэв.

Зураг 1. Бүртгэл Статистикийн хэлтсээс 2016 оны 4-р сарын 01-ний өдөр Аж Ахуй нэгж байгууллагын улсын тооллогын сургалт зохион байгууллаа.



1. Тооллогыг бүртгэл, статсителийн хэлтэс хариуцан явуулж дүн мэдээг хугацаанд нь НУБСГ-т хүргүүлэв. Тооллогоор: Ажил гүйцэтгэх гэрээг 96 тоологч, 6 шалгагчтай байгуулж ажилласан бөгөөд маягтаар тоолохдоо тоологч ААНБ-д өөрөө тооллогын жагсаалт, маршрутын дагуу явж очих, ААНБ-аас тооллогын комисстой ярилцаж цаг тохирч тоологч очиж тоолох, эсвэл ААНБ өөрөө дүүргийн статистикийн тасаг, хорооны Засаг даргын ажлын байранд ирж тоолуулж байлаа. Нийслэлийн тооллогын комиссоос тоологчийн ажилд хяналт тавих, хаяг тодорхойгүй ААН-ийн эрж хайсан ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор “Тоологчийн мониторингийн тэмдэглэл” гэсэн маягтыг 4000 мянган ширхэгийг хэвлэн өгсөн.

Дүүргийн тооллогын комиссоос харъяа төсвийн газар, хэлтэс, албадыг тооллогын хугацаанд шуурхай тоолуулахыг дахин сануулж ажиллав.

Тооллогын хугацаа дуусахад 7 хоног дутуу байхад онлайнаар тоолох ажиллагаанд өөрчлөлт гарсан, энэ нь ААНБ-ууд онлайнаар тоолуулна гэж шалтгалан тооллогод хамрагдахгүй байсан тул маягтаар тоолох ажлыг эрчимжүүлж ажилласаны үр дүнд тооллогыг амжилттай зохион байгуулж, 12670 ААНБ-ыг тооллогод хамруулж ажилласан байна.

2. Мал тэжээвэр амьтны судалгааг 2015 оны жилийн эцсийн мал тооллогын дүнд үндэслэн хийж тархаав.
3. Өрх нийгэм эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгааны түүврийг ХАӨМС-аас шууд түүвэрлэж авдаг болов.
4. Хөрөнгө оруулалтын судалгаанд улирал бүр 75 ААНБ хамрагдсан ба судалгааг программын дагуу боловсруулан НУБСГ-ын Статистикийн хэлтэст дамжуулан ажиллаа.
5. Статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх, өөрийн үйл ажиллагааг сурталчилах зорилгоор албан ёсны статистик болон захиргааны мэдээллийг нэгтгэн боловсруулж дүүргийн нийгэм, эдийн засгийн байдлын тухай статистикийн танилцуулгыг сар, улирлаар гарган аж ахуйн нэгж байгууллага болон холбогдох хүмүүст цаасаар хүргүүлдэг ба Нийслэлийн Статистикийн хэлтсийн [www.ubstat.mn](http://www.ubstat.mn) сайт болон дүүргийн [www.chingeltei.gov.mn](http://www.chingeltei.gov.mn) вэб хуудсанд тогтмол байршуулан ажиллаж байна. Мөн УБСЕГ-ын гаргасан сар бүрийн нийгэм эдийн засгийн байдал сэтгүүл, инфографикийг тархаан ажиллаа.
6. Байгаль орчны судалгаанд нийт 108 ААНБ түүвэрлэгдэн ирж судалгаанд хамрагдсан.
7. Тээврийн аж ахуй нэгж байгууллагуудын тээвэрлэсэн бүтээгдэхүүний, үйлдвэрлэгчийн үнийн судалгааг 6 ААНБ-с авсан.

## СУДАЛГАА ГАРЫН АВЛАГА

- Чингэлтэй дүүрэг тооны хэлээр нугалбар хийж тархаав
- Чингэлтэй дүүргийн өрх, хүн ам
- Аж үйлдвэрийн салбарын судалгаа

- Дүүргийн тохижилт, хөрөнгө оруулалтын судалгаа
  - Чингэлтэй дүүргийн барилгажилт судалгаа
  - Чингэлтэй дүүргийн боловсролын үзүүлэлт судалгаа
  - Холбооны салбарын танилцуулга судалгаа
  - Тээврийн салбарын танилцуулга судалгаа
  - Эрүүл мэндийн үйлчилгээ
  - Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын үйлчилгээ зэрэг судалгааг хийж тархаав
8. “Улаан бурхан Улаанууд” өвчины судалгааны хүрээнд 3-н хорооны 3-н хэсэгт судалгаа явуулах 180 өрхийн жагсаалтын дагуу мэдээ тодруулга авч НСГ-т илгээсэн.
  9. ХАОС-ны завсрын тооллогын дүнгээр эхний ээлжинд Чингэлтэй дүүргийн товч танилцуулга гаргалаа.
  - 10.7 хоног бүрийн үнийн танилцуулга хэвлэн гаргасан.

## **ГУРАВ: СТАТИСТИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, БОДЛОГЫН ЗӨВӨЛГӨӨ**

### **3.1 Хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сангийн хувьд:**

- ХАӨМСангийн тодруулгыг тухай бүрт нь тодруулж УБСЕГ-с илгээсэн.
  - Регистирийн дугаар өөрчлөгдсөн 44 иргэн
  - Иргэний бүртгэлийн мэдээллийн сангаас олдоогүй 75 иргэн
  - Харьяатаас гарсан 140 иргэн
  - Хүчингүй болсон 155
  - Нас барсан иргэдийн жагсаалт 980
  - Гэрлэлт байдал 128
  - 2016 оны шинэ төрсөн 3065 хүүхэд

## **ДӨРӨВ: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 4.1 Хэлтсийн даргын зүгээс ажилтан бүр дээр мэдээ тайлангийн ирцийн бүртгэл, мэдээний дамжуулалт зэргийг цаг минутаар хөтөлж бүртгэн хянаж ажиллаж байна.
- 4.2 Хэлтсийн ажилтан албан хаагчдын харилцааны соёл, мэндлэх, хүндлэх соёлыг бий болгож хэвшүүлэх мэдээлэгч байгууллагуудтайгаа хүндэлж харилцах зарчмыг барин ажиллаж байна.

- 4.3 Ажилтан албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг бүрдүүлж ажиллахад анхаарч, ногоон ажлын байрыг бий болгохоор ажиллаж байна.
- 4.4 Жил бүрийн 11 дүгээр сарын 11-ны өдөр Статистикийн алба үүсэн байгуулагдсан ойн арга хэмжээний хүрээнд “ Статистик боловсрол “ сэдэвт хичээлийг Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангуудын сурагчдад уламжлал болгон заадаг билээ. Энэ жил тус хэлтэсээс Чингэлтэй дүүргийн Ататуркийн нэрэмжит 5 дугаар бүрэн дунд сургуулийн ахлах бүлгийн сурагчдад хичээл заав.
- 4.5 Хороодын Эрүүл аюулгүй байдлын индексийн тоон мэдээллийн үнэн бодит байдал болон маягтын уялдаа холбоог шалгах нийслэлийн ажлын хэсэгтэй хамтран ажиллав. Хороодын Эрүүл аюулгүй байдлын индексийн тоон мэдээллийн үнэн бодит байдал болон маягтын уялдаа холбоог шалгах нийслэлийн ажлын хэсэгтэй хамтран ажиллав. Хэлтсийн ахлах мэргэжилтэн ЭАБИ-ийн шилдэг хороо шалгаруулах дүүргийн ажлын хэсэгт орж Багануур, Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул, Сүхбаатар дүүргийн дүүргийн 26 хороогоор орж, үнэлгээ дүгнэлт өгч ажилласан байна. Дүүргийн ЭАБИ-ийн нэгтгэл матрицыг гарган өгч ажиллаж байна.
- 4.6 Бүх нийтийн мод тарих өдрийн үеээр 19-р цэцэрлэгт өмнөх жил тарьсан шар хуайс, хайлаас зэрэг мод, бутаа арчлан усалж, цэцгийн мандал тарьж, арчлалт хамгаалалтанд нь байнга анхаарал тавин хамтран ажиллаж байна.
- 4.7 Төрийн албаны зөвлөлөөс баталсан, журам зааврын дагуу “Хүний нөөцийн бүртгэл, хувийн хэрэг”-ийг хүн бүр дээр хөтөлж, баяжилтыг байнга хийж ажиллаж байна.
- 4.8 Дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулдаг их цэвэрлэгээ, мод тарих болон бусад арга хэмжээнд хамт олноороо идэвхтэй хамтран ажиллав.
- 4.9 Нийслэлийн Өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг 2016 оны 05-р сарын 05-нд НӨХГ-ын мэргэжилтэн Х.Сэлэнгэ, Ч.Хоролгарав үзэж танилцан 93,7 хувьтай амжилттай дүгнүүлэв.
- 4.10 Эд хөрөнгийн улсын бүртгэл тооллогонд 2016 оны 05-р сарын 17-ний өдөр хамрагдаж, тооллогын бүртгэлийг НБСЕГ-ын газарт гаргаж өгөв.
- 4.11 2016.11.05-нд Үндэсний Статистикийн алба үүссэний 92 жилийн ойн шилжин явах цомын спортын арга хэмжээнд бусад дүүргүүдтэйгээ хамтран хамт олноороо оролцож гар бөмбөгийн тэмцээнд мөнгөн медаль хүртсэн.

ХЭЛТСИЙН ДАРГА

/Д.МӨНХЗУЛ/